



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/184

Булган сум

Г Нийлүүлэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа 60 ортой Сувиллын яслийн тоног төхөөрөмж (Булган сум) Багц-1 /Тавилга, эд хэрэглэл/-ийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу нийлүүлэгчээр шалгарсан "Хэрмэн шар үзүүр" ХХК-тай 27,400,000 (хорин долоон сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т олгосугай.

2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн аван данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Сувиллын ясли (Г.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг "Хэрмэн шар үзүүр" ХХК-ийн гүйцэтгэх захирал (М.Юмчин)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус барааны санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010266

03 дугаар сарын 27-ны ний өдрийн А/184 дүгээр захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Бараа нийүүлэх хугацаа	Гэрээнд зааснаар	М.Батчимэг
2	Баталгаат хугацаа	12 сар	Г.Мягмарсүрэн
3	Алданги	Хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.1 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт